

2025.07.02

№ А/25/28

Улаанбаатар хот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

Хувьцаа худалдах тухай

Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн 2025 оны 2 сарын 6-ны өдрийн 25/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. ТУЗ-өөс баталсан 2025 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн халаасны хувьцаанаас 166,666 ширхэг хувьцааг дахин гаргаж, нэгж хувьцааг 3,000 төгрөгийн ханшаар тооцон стратегийн хөрөнгө оруулагчид худалдсугай. Дахин гаргаж, эргэлтэнд оруулж байгаа хувьцаа нь нийт гаргасан хувьцааны 0.58 хувь болохыг тэмдэглэсүгэй;
2. Халаасны хувьцааг худалдахтай холбоотой хууль журмын дагуу холбогдох мэдэгдэл, мэдээллийг арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Энхзулд даалгасугай;
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудит эрхэлсэн захирал М.Мөнх-Эрдэнэд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЗОЛБОО